

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Давст сумын Ерөнхий боловсролын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/088/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаангом хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Б.Нямбуу

Утас: 70453799, Цахим хаяг: nyambuub@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2025.09.24 № УВА-2025/02/МД-СЭД-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Давст сумын сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М. БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>401,149,345.21</u>	<u>198,266,744.71</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	259,955,193.74	40,753,852.86
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	259,955,193.74	40,753,852.86
3121	Төгрөг	259,955,193.74	40,753,852.86
31211	Төрийн сангийн харилцах	259,955,193.74	40,753,852.86
33	АВЛАГА	00.00	306,528.38
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	197,841.85
335	Бусад авлага	00.00	108,686.53
3351	Байгууллагаас авах авлага	00.00	108,686.53
35	БАРАА МАТЕРИАЛ	141,194,151.47	157,206,363.47
351	Түүхий эд материал	248,500.00	529,314.80
35110	Тусгай зориулалттай материал	00.00	280,814.80
354	Хангамжийн материал	140,945,651.47	156,677,048.67
35410	Бичиг хэргийн материал	16,527,270.82	16,514,020.82
35420	Аж ахуйн материал	54,924,078.00	70,656,378.00
35460	Хүнсний материал	15,796,227.84	15,808,575.04
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,143,671,972.49</u>	<u>1,144,357,898.22</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,143,671,972.49	1,144,357,898.22
392	Биет хөрөнгө	1,095,920,992.49	1,096,606,918.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,543,621,294.00	1,560,621,294.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-643,287,155.96	-659,423,527.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	312,444,648.25	324,480,338.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	-195,480,016.76	-218,825,664.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	147,935,035.14	173,144,801.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	-91,490,661.24	-105,568,172.05
39217	Номын фонд	22,177,849.06	22,177,849.06
393	Биет бус хөрөнгө	47,750,980.00	47,750,980.00
39301	Программ хангамж	890,000.00	890,000.00
39302	Хасагдуулга	-890,000.00	890,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	47,750,980.00	47,750,980.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,544,821,317.70</u>	<u>1,342,624,642.93</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>11,690,500.00</u>	<u>23,506,917.75</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,690,500.00	23,506,917.75
413	Өглөг	11,690,500.00	23,506,917.75
4136	Бусад өглөг	11,690,500.00	23,506,917.75
41361	Байгууллагад төлөх өглөг	11,690,500.00	23,506,917.75
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,533,130,817.70</u>	<u>1,319,117,725.18</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,533,130,817.70	1,319,117,725.18

	Засгийн газрын оруулсан капитал/ЗГСан/ орон нутгийн сан	395,975,462.50	395,975,462.50
51100	Өмч-Төрийн сан	395,975,462.50	395,975,462.50
512	Хуримтлагдсан үр дүн	910,593,316.48	696,580,223.96
51210	Өмнөх үеийн үр дүн	910,593,316.48	910,593,316.48
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-214,013,092.52
51900	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	226,562,038.72	226,562,038.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,544,821,317.70</u>	<u>1,342,624,642.93</u>

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,415,204,667.50	1,322,831,271.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	84,311,267.50	60,431,870.70
120	Нийтлэг татварын бус орлого	84,311,267.50	60,431,870.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	36,624,642.50	10,501,414.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,697,900.00	1,162,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	137,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- бараа материал	34,926,742.50	9,201,814.80
120009	Бусад орлого	56,000.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	47,630,625.00	49,930,455.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,330,893,400.00	1,262,399,400.39
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,172,859,400.00	1,125,074,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,172,859,400.00	1,125,074,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	158,034,000.00	137,325,300.39
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	158,034,000.00	137,325,300.39
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,184,835,760.88	1,536,844,363.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,184,835,760.88	1,536,844,363.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,156,765,261.46	1,495,581,752.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	792,420,639.29	1,051,589,620.00
210101	Үндсэн цалин	501,913,871.44	624,982,446.00
210102	Нэмэгдэл	243,979,844.73	328,891,214.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	32,100,000.00
210104	Урамшуулал	46,526,923.12	65,615,960.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,749,587.32	130,284,731.88
210201	Тэтгэврийн даатгал	63,266,468.83	89,148,678.45
210202	Тэтгэмжийн даатгал	7,865,416.43	10,488,079.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,095,251.66	5,486,195.34
210204	Ажилгүйдлийн даатгал	3,704,309.41	5,032,355.47

210205	Эрүүл мэндийн даатгал	14,818,140.99	20,129,422.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	158,049,888.33	155,251,217.75
210301	Гэрэл, цахилгаан	14,139,454.16	13,670,896.23
210302	Түлш, халаалт	141,880,434.17	138,880,321.52
210303	Цэвэр, бохир ус	2,030,000.00	2,700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,821,788.43	9,893,400.00
210401	Бичиг хэрэг	2,966,760.00	2,662,450.00
210402	Тээвэр, шатахуун	4,972,858.00	7,230,950.00
210408	Бараа материал акталсны зардал	882,170.43	00.00
2105	Нормативт зардал	32,698,475.96	57,089,742.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	155,100.00
210502	Хоол, хүнс	32,698,475.96	56,934,642.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	4,898,300.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	4,898,300.00
2107	Томилолт, зочны зардал	100,000.00	1,190,000.00
210702	Дотоод албан томилолт	100,000.00	1,190,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,113,335.18	16,723,900.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,216,600.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	806,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,896,735.18	15,917,500.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,811,546.95	68,660,840.17
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	671,800.00	5,896,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,920,464.95	53,559,530.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,070,499.42	41,262,610.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,641,016.20	41,262,610.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,824,216.20	30,673,810.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,816,800.00	10,588,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	429,483.22	00.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	429,483.22	00.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>230,368,906.62</u>	<u>-214,013,092.52</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	264,000.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	264,000.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-264,000.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>230,104,906.62</u>	<u>-214,013,092.52</u>

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

<i>/төгрөгөөр/</i>			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,332,647,300.00	1,263,699,000.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,753,900.00	1,299,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,753,900.00	1,299,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,697,900.00	1,299,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,697,900.00	1,162,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	137,000.00
120009	Бусад орлого	56,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,330,893,400.00	1,262,399,400.39
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,172,859,400.00	1,125,074,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,172,859,400.00	1,125,074,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	158,034,000.00	137,325,300.39
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	158,034,000.00	137,325,300.39
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,167,451,654.00	1,478,585,341.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,167,451,654.00	1,478,585,341.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,139,382,570.78	1,435,966,040.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	791,519,221.56	1,053,979,765.33
210101	Үндсэн цалин	503,830,207.71	630,188,761.54
210102	Нэмэгдэл	244,663,330.73	329,492,890.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	31,940,000.00
210104	Урамшуулал	43,025,683.12	62,358,112.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,954,577.26	128,201,114.93
210201	Тэтгэврийн даатгал	66,471,462.77	87,240,077.51
210202	Тэтгэмжийн даатгал	7,865,416.43	10,571,260.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,095,251.65	5,255,770.43
210204	Ажилгүйдлийн даатгал	3,704,309.41	4,835,414.72
210205	Эрүүл мэндийн даатгал	14,818,137.00	20,298,591.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	154,660,516.78	131,745,300.00
210301	Гэрэл, цахилгаан	10,750,082.61	10,767,522.22
210302	Түлш, халаалт	141,880,434.17	118,277,777.78
210303	Цэвэр, бохир ус	2,030,000.00	2,700,000.00
2105	Нормативт зардал	46,555,420.00	55,590,300.00
210502	Хоол, хүнс	46,555,420.00	55,590,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	5,580,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	5,580,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,113,335.18	17,079,900.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,216,600.00	1,162,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,896,735.18	15,917,500.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,579,500.00	43,789,660.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,983,400.00	37,092,960.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,596,100.00	6,696,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,069,083.22	42,619,300.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,639,600.00	42,619,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,822,800.00	32,030,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,816,800.00	10,588,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	429,483.22	0.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	429,483.22	0.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	165,195,646.00	-214,886,340.88
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	4,315,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	4,315,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	4,315,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	4,315,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-4,315,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	165,195,646.00	-219,201,340.88
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	94,759,547.74	259,955,193.74
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	259,955,193.74	40,753,852.86

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 1-нээрх үлдэгдэл	395,975,462.50	226,562,038.72	1,128,243,276.80	00.00	1,750,780,778.02
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	395,975,462.50	226,562,038.72	1,128,243,276.80	00.00	1,750,780,778.02
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00

C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-451,341,649.70	00.00	-451,341,649.70
C08	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	395,975,462.50	226,562,038.72	910,593,316.48	00.00	1,533,130,817.70
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	395,975,462.50	226,562,038.72	910,593,316.48	00.00	1,533,130,817.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	395,975,462.50	226,562,038.72	910,593,316.48	00.00	1,533,130,817.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-214,013,092.52	00.00	-214,013,092.52
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	395,975,462.50	226,562,038.72	696,580,223.96	00.00	1,319,117,725.18

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ЭЗА	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	259,955,193.74	(259,955,193.74)	-
2	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,152,174,700.00	1,126,373,700.00	25,801,000.00	97.76
3	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,152,174,700.00	1,125,074,100.00	27,100,600.00	97.65
4	Улсын төсвөөс санхүүжих	1,152,174,700.00	1,125,074,100.00	27,100,600.00	97.65
15	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	1,299,600.00	(1,299,600.00)	-
16	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,162,600.00	(1,162,600.00)	-
17	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	137,000.00	(137,000.00)	-
32	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,365,617,685.62	1,345,575,040.88	20,042,644.74	98.53
33	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,365,617,685.62	1,345,575,040.88	20,042,644.74	98.53
34	Бараа, үйлчилгээний зардал	1,322,251,085.62	1,302,955,740.88	19,295,344.74	98.54
35	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,069,513,945.28	1,053,979,765.33	15,534,179.95	98.55
36	Үндсэн цалин	625,559,374.49	630,188,761.54	(4,629,387.05)	100.74
37	Нэмэгдэл	366,695,757.83	329,492,890.83	37,202,867.00	89.85

38	Унаа, болон бусад нөхөн олговор	3,719,000.00	31,940,000.00	(28,221,000.00)	858.83
39	Урамшуулал	73,539,812.96	62,358,112.96	11,181,700.00	84.80
41	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,250,239.72	128,201,114.93	4,049,124.79	96.94
42	Тэтгэврийн даатгал	89,988,833.26	87,240,077.51	2,748,755.75	96.95
43	Тэтгэмжийн даатгал	10,565,301.57	10,571,260.89	(5,959.32)	100.06
44	ҮОМШӨ ний даатгал	5,282,650.89	5,255,770.43	26,880.46	99.49
45	Ажилгүйдлийн даатгал	5,282,650.89	4,835,414.72	447,236.17	91.53
46	Эрүүл мэндийн даатгал	21,130,803.11	20,298,591.38	832,211.73	96.06
60	Нормативт зардал	55,590,300.00	55,590,300.00	-	100.00
62	Хоол, хүнс	55,590,300.00	55,590,300.00	-	100.00
73	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	16,073,200.62	17,079,900.62	(1,006,700.00)	106.26
74	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,162,400.00	(1,162,400.00)	-
79	Мэдээллийн технологийн зардал	16,073,200.62	15,917,500.62	155,700.00	99.03
83	Бараа үйлчилгээний бусад зардал	48,823,400.00	48,104,660.00	718,740.00	98.53
84	Бараа үйлчилгээний бусад зардал	41,876,700.00	41,157,960.00	718,740.00	98.28
85	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,946,700.00	6,946,700.00	-	100.00
96	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,366,600.00	42,619,300.00	747,300.00	98.28
100	Бусад урсгал шилжүүлэг	43,366,600.00	42,619,300.00	747,300.00	98.28
104	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	32,777,800.00	32,030,500.00	747,300.00	97.72
108	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	10,588,800.00	10,588,800.00	0.00	100.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	259,955,193.74	(259,955,193.74)	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	40,753,852.86	(40,753,852.86)	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	34.00	34.00	0.00	100%
134	Удирдах ажилтан	3.00	3.00	0.00	100%
135	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00	0.00	100%
136	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	-	100.00

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

/төгрөгөөр/

ЭЗА	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	137,325,300.39	137,325,300.00	0.39	100.00
8	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	137,325,300.39	137,325,300.00	0.39	100.00
9	Орон нутгийн төсвөөс	137,325,300.39	137,325,300.00	0.39	100.00

32	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	137,325,300.00	137,325,300.00	-	100.00
33	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	137,325,300.00	137,325,300.00	-	100.00
34	Бараа, үйлчилгээний зардал	137,325,300.00	137,325,300.00	-	100.00
47	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	131,745,300.00	131,745,300.00	-	100.00
48	Гэрэл цахилгаан	10,767,522.22	10,767,522.22		100.00
49	Тулш, халаалт	118,277,777.78	118,277,777.78	-	100.00
50	Цэвэр, бохир ус	2,700,000.00	2,700,000.00	-	100.00
60	Нормативт зардал	-	-	-	-
62	Хоол, хүнс	-	-	-	-
64	Эд хогшил худалдан авах	5,580,000.00	5,580,000.00	-	100.00
68	Урсгал засвар	5,580,000.00	5,580,000.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Давст сумын Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд бага дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих ажлыг мэргэжлийн болон захиргааны удирдлагаар ханган ажиллаж, 2025-2026 оны хичээлийн жилд “Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, сурагчдыг бие даан сурах арга барилд сургаж, чадваржуулахад хамтын ажиллагааг чиглүүлнэ” зорилгын дор 13 зорилт дэвшүүлэн сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон, нягтлан бодох бүртгэлийн стандарт бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 202,196.7 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	259,955.2	40,753.9	-219,201.3
Авлага	-	306.5	306.5
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	141,194.5	157,206.4	16,011.9
Үндсэн хөрөнгө	1,143,671.9	1,144,357.9	686.0
Нийт хөрөнгө	1,544,821.3	1,342,624.6	-202,196.7
Өр төлбөр	11,690.5	23,506.9	11,816.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,533,130.8	1,319,117.7	-214,013.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,544,821.3	1,342,624.6	-202,196.7

Дээрх хүснэгтээс харахад Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь 2024 онд 259,955.2 төгрөг байсан бол 2025 онд 40,753.9 мянган төгрөг болж буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 157,206.4 мянган төгрөг болж 16,011.9 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, бичиг хэргийн материал, түлш шатах тослох материал, хүнсний материал, эм боох материал өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 1,144,357.9 мянган төгрөг болж 686.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 4,315.0 мянга, Давст сумын ойн хүрээнд 49,930.6 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан, тайлант онд 53,559.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 23,506.9 мянган төгрөг болж 11,816.4 мянган төгрөгөөр өссөн нь түлш халаалтын зардал, гэрэл цахилгааны зардлын өр төлбөр байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,319,117.7 мянган төгрөг болж 214,013.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,380,778.6 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 148,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 23,880.9 мянган төгрөгөөр өсгөж, улсын төсвөөс 1,147,792.3 мянга, төсөвт байгууллагын үйлажиллагааны орлогоос 256,867.2 мянга, орон нутгийн төсвөөс 137,325.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,147,792.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 137,325.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 256,867.2 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,125,074.1 мянга, орон нутгийн төсвөөс 137,325.3 мянга, үйл ажиллагааны орлого 1,299.6 мянга, нийт 1,263,699.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,126,373.7 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна. Улсын төсвийн дансны мөнгөн хөрөнгө 40,753.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ /80226/	1,335.0	1,335.0	0.0	100%
2	Хүүхэд хамгаалал /80233/	1,668.0	1,501.2	166.8	90.0%
3	Сургалт семинар /80312/	855.4	712.9	142.5	83.3%
4	Эрүүл мэндийг дэмжих /81605/	1,602.0	1,130.5	471.5	70.6%
5	Үдийн цай хөтөлбөр	32,777.8	31,972.5	805.3	97.5%
6	Дотуур байрны үйлчилгээ /81806/	228,341.7	204,429.8	23,911.9	89.5%

7	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин /81816/	11,689.5	11,689.5	-	100.0%
8	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх/81823/	4,733.5	4,385.3	348.2	92.6%
9	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр /81827/	16,291.1	16,291.1	-	100%
10	Боловсролын стандарт, сургалтын хэвийн үйл ажиллагаа /81834/	789,161.0	788,161.0	1,000.0	99.9%
11	Сургалтын хэвийн үйл ажиллагаа /81835/	61,700.8	45,410.3	16,290.5	73.6%
13	Сурах бичгийн түрээс /81848/	1,162.6	1,162.4	0,2	99.9%
14	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх /81875/	3,675.4	3,675.4	-	100%
15	Нэмэлт- Дээд шатны төсвөөс хуваарилсан /83603/	137.0		137.0	0.0%
16	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал /80111/	137,325.3	137,325.3	-	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5, 2.6-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	890.0	Асoлuос программ ашигладаг.
2	Унаа, хоолны зардал	31,940.0	2025 онд 31,940.0 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна.
3	Сургалт, семинар	-	Сургалт, семинарын зардал гараагүй байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	-	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	-	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Хэвлэл мэдээлэл	-	Хэвлэл мэдээллийн арга хэмжээнд зардал гараагүй байна.
7	Орон тоо	-	Увс аймгийн Давст сумын сургууль нь 2025 онд 34 орон тоо ажиллахаар батлагдсанаас 39 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна. Энэ илүү орон тоон Хандгайт Боршоо боомтын бага сургууль 2025 оны 11 дүгээр сард байгууллагдаж 5 багш ажилчин авч ажилуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант Давст сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотуур байр, үдийн хоолны 2 тендер худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна. Үүнд: Хүүхдийн үдийн хоолны материал нийлүүлэх 32,835.8 мянган төгрөг, дотуур байрны хүүхдийн хоол 55,590.3 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулан шалгарсан компанитай гэрээ байгуулан, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямбуу гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн нийт зардлын 1,021,550.6 мянган төгрөгийн 1 хувиар буюу 10,215.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,536,844.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 15,368.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 12,294.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсөв захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 183 мэдээллээс хугацаандаа оруулсан 51, хугацаа хоцроон байршуулсан 5, хугацаандаа байршуулаагүй 127 мэдээлэл байна.

Давст сумын Ерөнхий боловсролын сургууль нь нь шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,165,067.4 мянган төгрөгийн 51 орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 796,824.5 мянган төгрөгийн 76 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 65,377.3 мянган төгрөгийн 5 зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроон байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,256.5 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн биелэлтийг 2025

оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 39 дүгээр албан бичгээр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж санхүүгийн тайлангийн аудитын fas.audit.mn систем бүртгэсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,967,788.1 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 5,896.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,961,891.9 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өглөө.

Залруулсан алдаа

Давст сумын Ерөнхий боловсролын сургууль нь үр дүнгийн тайланд хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлыг 5,896.2 мянган төгрөгийг дутуу тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.6 дахь заалт “Бүх зардал”, гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

5.2 Албан шаардлага:

Илрүүлэлт:

Давст сумын Ерөнхий боловсролын сургууль нь шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,165,067.4 мянган төгрөгийн 51 орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 796,824.5 мянган төгрөгийн 76 шийдвэрийн мэдээлэлийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 65,377.3 мянган төгрөгийн 5 зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 дахь заалтад “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь заалтад “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь заалтад “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үр дүнгийн тайлан тусгаагүй	1	5,896.2					1	5,896.2				

Дүн	1	5,896.2					1	5,896.2				
-----	---	---------	--	--	--	--	---	---------	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
5 сая төгрөгийн үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ байршуулаагүй	1	1,165,067.4			1	1,1165,067.4		
Төсөв өмч, хөрөнгө мөнгө зарцуулах шийдвэр байршуулаагүй	1	796,824.5			1	796,824.5		
Дүн	2	1,961,891.9			2	1,961,891.9		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/Б.НЯМБУУ/



2026 оны 02 сарын 24-ний өдөр



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/23/А-20711 99
УБД-2026/088/НД-СТД-ТМЗ

Улаангом

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалтад заасан цаглабарт хугацаанд Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,165,067.4 мянган төгрөгийн 51 орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 796,824.5 мянган төгрөгийн 76 шийдвэрийн мэдээлэлийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 65,377.3 мянган төгрөгийн 5 зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроон байршуулсан байна.

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 дахь заалтад “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь заалтад “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь заалтад “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11-

д “Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөн ажиллаж биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Давст сумын Ерөнхий болосролын сургуулийн захирал С.Баясгалан , Нягтлан бодогч Б.Уранчимэг нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.НЯМБУУ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ